



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 315

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.10, 5.1 дэх заалт, Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны А/1060 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өмнөговь аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 134,035,000.00 (нэг зуун гучин дөрвөн сая гучин таван мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Давааням, Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000981
15-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 2-р дугаар сарын 2-ны өдрийн
3-р дугаар тогтоолын хавсралт

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
БИЙ БОЛСОН, ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, ӨМНӨГОВЬ АЙМАГ
ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт үнэ (төгрөг)
1	Компьютер /Dell/	ш	4,000,000	4	16,000,000.00
2	Таблет /Microsoft Surface Pro I5/	ш	4,000,000	3	12,000,000.00
3	Drone / хөдөлгөөнт зураг авагч DJI /	ш	11,000,000	1	11,000,000.00
4	Камер /гадна гэрэлтүүлэг/	ш	600,000	16	9,600,000.00
5	Ухаалаг дэлгэц	ш	7,765,000	1	7,765,000.00
6	Гадна хаяг	ш	3,000,000	1	3,000,000.00
7	Тек /үйлчилгээний/	ш	750,000	10	7,500,000.00
8	Сандал	ш	150,000	10	1,500,000.00
9	Хүлээлгийн сандал	ш	500,000	3	1,500,000.00
10	Архивын шүүгээ	ш	1,173,913	46	54,000,000.00
11	Сургалтын өрөөний ширээ	ш	330,000	24	7,920,000.00
12	Шүүгээ	ш	450,000	5	2,250,000.00
12	Нийт дүн				134,035,000.00 (нэг зуун гучин дөрвөн сая гучин таван мянга)